



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар Д/152

Хэрлэн сум

Мал, амьтны сэг зэм устгал, орчны
халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд цас зудын улмаас үхэж хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 20-ыг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийг орон нутгийн байгууллага, малчид, иргэдийн оролцоотой шуурхай зохион байгуулж, шаардагдах зардал, тээврийн хэрэгслийн асуудлыг шийдвэрлэж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Уг арга хэмжээнд шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ